Засгийн газрын 2005 оны 216 дугаар

тогтоолын хавсралт

"ЦАХИМ МОНГОЛ" ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

1. Энэхүү хөтөлбөр нь мэдээлэл, харилцаа холбооны технологи (цаашид "МХХТ" гэх)-ийн салбарт төрөөс баримтлах дунд хугацааны (2005-2012 он) хөгжлийн бодлого, авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлно.

Дэлхийн улс орнуудад аж үйлдвэржсэн эринээс мэдээлэлжсэн эринд шилжих үйл явц улам эрчимжин мэдлэгт тулгуурласан нийгмийг цогцлон байгуулж нийгмийн баялаг, үнэт зүйлсийг бүтээх эх сурвалж нь мэдлэг, мэдээлэл гэдгийг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч улс төр, эдийн засаг, нийгмийн бүхий л хүрээнд мэдээлэл, харилцаа холбооны технологийг өргөнөөр нэвтрүүлэн хэрэглэж байна.

Монгол Улсын хувьд МХХТ-ийн давуу хэрэглээг бүрдүүлж, түүнийг хөгжлийн хурдасгуур болгон мэдлэгт тулгуурласан нийгмийг байгуулах, Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл болгох шаардлага зүй ёсоор урган гарсан юм. Иймээс Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт "Цахим Монгол" үндэсний хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх, МХХТ-ийн хөгжилд өндөр ач холбогдол өгч олон шинэлэг зорилтуудыг дэвшүүлэн тавьсан болно.

2. Хөтөлбөрийн үндэслэл

Улс төр, нийгэм, эдийн засгийн бүхий л хүрээнд МХХТ-ийг бүтээлчээр нэвтрүүлэх, төрийн удирдлагын үр нөлөө, төрийн үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, мэдээллийн найдвартай тогтолцоо бий болгох, мэдээлэлжсэн нийгмийг байгуулах, мэдээлэлжүүлэлтийн хоцрогдлыг багасгах, МХХТ-ийн дэд бүтцийг хөгжүүлэх, мэдээлэл хүртэх тэгш бус байдал, тоон ялгааг арилгах, салбарын эрх зүйн тааламжтай орчинг бүрдүүлэх шаардлага тавигдаж байна.

Дэлхийн ихэнх улс орон өнгөрсөн зууны сүүлчээс эхлэн МХХТ-ийг хөгжүүлэх урт, богино хугацааны стратеги хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, төрийн удирдлага, үйлчилгээ, үйл ажиллагаанд МХХТ-ийг өргөн ашиглан шинэ төрлийн хэрэглээг бий болгоход зарцуулах хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлж байна.

Дэлхийн олон орон холбоо, мэдээллийн дэд бүтцийг бий болгох үндэсний хөтөлбөрийг дэвшүүлэн хэрэгжүүлж байна. Тухайлбал, Сингапурын "Ухаалаг арал" хөтөлбөр, БНСУ-ын "Мэдээллийн дэд бүтэц" үндэсний төлөвлөгөө, Малайзын "Мултимедиа супер коридор" хөтөлбөр, Япон Улсын "Цахим Япон" зэрэг олон хөтөлбөрийг энд дурдаж болно. Эдгээр орнуудад хэрэгжсэн эхний хөтөлбөрүүд амжилттай болсон тодийгүй дараагийн шатыг хэрэгжүүлэхдээ өндөр ач холбогдол өгч төрийн бодлого, санхүүгийн дэмжлэгээ нэмэгдүүлсээр байна.

Өндөр хурдтай хөгжиж байгаа Азийн ихэнх орнуудын хөгжлийн гол түлхүүр нь МХХТ болж байна. Ялангуяа газар нутаг уудам, хүн ам сийрэг суурьшилтай, далайд гарцгүй манай орны хувьд МХХТ-ийн боломжийг түлхүү ашиглах нь нэн чухал юм. Мөн мэдлэгт тулгуурласан мэдээлэлжсэн нийгэм байгуулахад МХХТ-ийг нийгмийн бүх салбарт эрчимтэй нэвтрүүлэх зайлшгүй шаардлага байгаа юм.

МХХТ-ийг туушгай нэвтрүүлэхэд дараахь хүчин зүйлс саад болж байна. Үүнд:

- Эрх зүй, зохицуулалтын механизмууд боловсронгуй болоогүй
- Төрийн байгууллагуудын удирдлагын шатанд МХХТ-ийн талаархи ойлголт цэгцтэй биш, ашиглалт хангалттүй, нэгдсэн тогтолцоо бүрдээгүй
- Энэ салбарт хөрөнгө оруулалтын нэгдмэл бодлого бүрдээгүй
- МХХТ-ийн салбарын хүний нөөц дутагдалтай
- Харилцаа холбооны үндсэн сүлжээний хурд, багтаамж нь өнөөгийн өсөн нэмэгдэж буй хэрэгцээ шаардлагыг хангахгүй байгаа
- Мэдээллийн аюулгүй байдлыг хангах техник, технологи, эрх зүй, зохион байгуулалтын арга хэмжээ авагдаагүй
- Тоон ялгаа, мэдээллийн тэгш бус байдал буурахгүй байгаа
- Боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлт, шинжлэх ухаан, урлаг, соёлын салбарт МХХТ-ийн хэрэглээ суп хөгжсөн
- МХХТ улс даяар жигд нэвтрэгүй, орон нутагт МХХТ-ийн техник хангалт суп хийгдсэн зэрэг нөхцөлийг тус тус дурдаж болно.

Дээрх сөрөг хүчин зүйлсийн нөлөөллийг багасгах, улмаар мэдлэгт тулгуурласан эдийн засгийн шинэ орчин, шинэ чадавхийг бүрдүүлэх, МХХТ-ийг өргөн хэрэглэх болгоход энэхүү хөтөлбөр чиглэгдэнэ.

Төслийг боловсруулахад Мянганы хөгжлийн зорилтууд, Мэдээлэлжсэн нийгмийн талаархи дэлхийн дээд хэмжээний чуулга уулзалтаар батлагдсан Үйл ажиллагааны төлөвлөгөө болон Зарчмын тунхаглал зэрэг дэлхийн хэмжээний чухал арга хэмжээнүүдийн үр дүнг анхаарсан болно.

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараахь боломж бүрдэнэ. Үүнд:

- Бүх нийтийг өндөр хурдтай, хямд, хялбар ашиглаж болохуйц мэдээлэл, харилцаа холбооны сүлжээний дэд бүтцээр тэгш, зохистой байдлаар ханган мэдээлэл, харилцаа холбооны сүлжээний аюулгүй, найдвартай ажиллагааг хангах
- Мэдлэгт тулгуурласан эдийн засгийн шинэ орчин, шинэ чадавхийг бий болгох замаар дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэн ядуурлыг бууруулахад хувь нэмэр оруулах, ард түмний амьжиргааны түвшинг дээшлүүлж МХХТ-ийг эдийн засгийн тогтвортой өсөлт болон технологийн хөгжлийг дэмжих хөдөлгөгч хүч болгон ашиглах
- Олон нийтийн мэдээллийн нээлттэй орчинг бүрдүүлэх замаар улс төр, эдийн засаг, нийгэм, боловсрол, шинжлэх ухаан, урлаг, соёлын талаархи мэдээллийг хүртэх тэгш боломжийг бий болгох
- Өнөөгийн нийгмийн тулгамдсан асуудал авилгал, хүнд суртлыг арилгахад МХХТ-ийн давуу талыг ашиглах
- Мэдээллийн эрин зуунд Монгол Улсын нийгмийн үнэт зүйл болон түүх, соёлын өвийг хадгалах
- Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг бэхжүүлэхэд МХХТ-ийг ашиглах
- МХХТ-ийг хүний нөөцийг хөгжүүлэх болон чадавхийг дээшлүүлэхэд ашиглах, ялангуяа МХХТ-ийн боловсрол эзэмшүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрэлт хэрэгцээнд тохирсон тусгай хөтөлбөрийг дэмжих
- Мэдээлэлжсэн нийгэм дэх мэдээлэл, харилцаа холбооны технологийн төрөл бүрийн сүлжээ, үйлчилгээг хөгжүүлэхэд хувийн хэвшлийн оролцоо болон иргэний нийгмийн санал санаачилгад тулгуурлах

Олон улсын хамтын ажиллагааг идэвхжүүлж үр дүнтэй төсөл, хөтөлбөр, харилцан ашигтай хөрөнгө оруулалтыг дэмжих.

3. Хөтөлбөрийн зорилго

Энэхүү хөтөлбөрийн эрхэм зорилго нь Мэдээлэл, харилцаа холбооны технологийг XXI зууны хөгжлийн үндсэн хурдасгуур гэж үзэж, Монгол Улсад мэдлэгт тулгуурласан мэдээлэлжсэн нийгмийг байгуулахад оршино.

Эдийн засгийн шинэ орчин, оюунлаг чадавхийг бий болгох, улс орны өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, тогтвортой хөгжлийг хангах замаар хүн амын амьдралын чанарыг сайжруулж, 2012 онд МХХТ-ийн хөгжлийн гол үзүүлэлтүүдээр Ази тивд эхний арван улсын тоонд орох зорилгыг энэхүү хөтөлбөрийн хүрээнд дэвшүүлж байна.

Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжлийн гол үзүүлэлтүүдийг дэлхийн цахилгаан холбооны байгууллагаас гаргадаг эвлэмжид үндэслэн тодорхойлох, эдгээр үзүүлэлтэд хүрэхэд шаардлагатай санхүү, хууль эрх зүй, сургалт сурталчилгааны арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлнэ.

4. Хөтөлбөрийн зорилтууд

Энэхүү хөтөлбөрийн эрхэм зорилгод хүрэхийн тулд дараахь зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

- МХХТ-ийг нэвтрүүлэх, хөгжүүлэх эрх зүйн орчин бий болгох
- Улс орныг хамарсан нийтэд хүртээмжтэй мэдээлэл, харилцаа холбооны өндөр хурдны нэгдсэн сүлжээ байгуулах
- Өндөр хурдны нэгдсэн сүлжээг олон улсын урсгалд холбох
- МХХТ-ийн салбарт бизнесийн шударга өрсөлдөөнийг дэмжих
- Мэдээллийн бүх нийтийн үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх
- Төрийн мэдээллийн нэгдсэн тогтолцоо (Integrated system), мэдээллийн нэгдсэн санг байгуулж "Төрийн ой" (Government institutional memory)-г бий болгох
- МХХТ-д тулгуурласан удирдлагын шинэ загварыг бий болгож цахим засагпалыг хэрэгжүүлэх
- Хүний эрхийг хамгаалах зорилгоор цахим ардчиллыг хөгжүүлэх санал, санаачилгыг дэмжих
- Цахим арилжааг ашиглан бизнес эрхлэгчдийн өрсөлдөх чадварыг дэшлүүлж эдийн засгийн шинэ орчинг бүрдүүлэх
- МХХТ-ийн ололт, амжилтыг эдийн засгийн салбарт нэвтрүүлж мэдлэгт тулгуурласан үйлдвэрлэлийг хөгжүүлэх
- Нийгмийн салбарт МХХТ-ийг нэвтрүүлж иргэдэд чиглэсэн, үр дүнтэй нийгмийн бодлогыг хэрэгжүүлэх
- МХХТ-ийг ашигласан хүний нөөцийг бүх шатанд бэлтгэх, хөгжүүлэх
- Бүх нийтийн боловсролыг дэмжлүүлэх

LIVEWORKSHEETS

- Мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоог бий болгох
- МХХТ-ийг иргэдийн амьжиргаяны түвшинг дээшлүүлэх, амьдралын хэв маягийг тодорхойлох чухал хүчин зүйл болгох
- Бүх нийтийг компьютержүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж 1000 хүнд ногдох компьютерийн тоог 2012 он гэхэд 100-д хүргэх .

5. Монгол Улсын мэдээлэл, харилцаа холбооны технологийн өнөөгийн байдал

5.1. Бодлого зохицуулалт 2000 онд Улсын Их Хурлаас "Монгол Улсын мэдээлэл, холбооны технологийн хөгжлийн 2010 он хүртэлх үзэл баримтлал", 2002 онд Засгийн газраас "Мэдээлэл холбооны технологийг дунд хугацаанд хөгжүүлэх стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө"-г тус тус батлсан бөгөөд Харилцаа холбооны тухай, Радио долгионы тухай, Шуудангийн тухай, Патентийн тухай, Зохиогчийн эрхийн тухай, Оюуны өмчийг хамгаалах тухай, Технологи дамжуулах тухай, Шинжлэх ухаан, технологийн тухай зэрэг хуулиуд нь мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарын үйл ажиллагааг зохицуулж байна.

Харилцаа холбооны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2001 онд батлсны үндсэн дээр харилцаа холбооны салбарыг либеральчлах,шударга өрсөлдөөнийг бий болгох,зохицуулалтын шинэ, бие даасан тогтолцоог бий болгож Харилцаа холбооны зохицуулах хороог байгуулан, бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн үйл ажиллагааг эхлүүлэхэд байна.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт "Эдийн засгийн өсөлтийг хангахад чиглэсэн шинэ чадавхийг бий болгох зорилгоор аялал жуулчлалын болон мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хөгжлийг шинэ шатанд гаргах" гол зорилтыг тодорхойлсон юм. Энэхүү гол зорилтыг биелүүлэх арга хэмжээний хүрээнд:

- "Цахим Монгол" хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- Цахим засаглалыг нэвтрүүлснээр төрөөс иргэд, байгууллагад үзүүлэх үйлчилгээг шинэ шатанд гаргах, иргэдийн зүгээс төр, засаг хандах мэдээллийн шинэ урсгалыг бий болгох
- Улс орны хэмжээнд нэгдмэл кодчиллыг бий болгосноор мэдээллийн нэгдсэн системийг бүрдүүлэх
- Цахилгаан холбооны суурь сүлжээг шинэчлэн олон улсын өргөн зурвасын сүлжээнд нэгдэх
- Мэдээлэл, харилцаа холбооны технологийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох
- Эрчим хүчний байнгын эх үүсвэртэй, хүн ам төвлөрсөн газрын сүргууль, айл өрхийг компьютержүүлж, интернэтийн үйлчилгээний хүрээ, хүртээмжийг өргөжүүлэх
- Төвийн болон сэргээгдэх эрчим хүчинд холбогдсон сумын тов, суурин газрын мэдээлэл холбооны сүлжээний шинэчлэлтийг үе шаттайгаар хэрэгжүүлэх
- Программ хангамжийн эрэлтийг нэмэгдүүлж бүтээгдэхүүний өсөлтийг дэмжих
- Томоохон суурин газруудын автомат телефон станцыг тоон технологид үе шаттай шилжүүлнэ. Улсын хэмжээнд 100 хүнд ноогдох суурин болон хөдөлгөөнт телефон хэрэглэгчдийн тоог 2012 онд дунджаар 40-д хүргэх
- Интернэт хуваалцаа, үйлчилгээ, зайны сургалт, цахим нийтлэл, зайны оношилгоог эрчимтэй нэвтрүүлэх
- Телевизийн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлснээр телевизийн олон сувгийг орон даяар үзэгдэг болох
- Гуламж, талбай, албан байгууллага, айл өрх бүрийг хаягжуулж, шуудангийн бүсийн тогтолцоонд шилжүүлэх
- Бүх шатны шуудан хүргэлтийн тогтолцоог боловсронгуй болгож, шуудангийн зах зээлийн өрсөлдөөний зохицуулалтын механизмыг бүрдүүлэн шуудан санхүүгийн болон электрон хуваалцааны үйлчилгээг нэвтрүүлэх
- Улиастай-Улаангом-Мөрөн чиглэлийн тоон сүлжээг байгуулах
- Улаанбаатар-Дашинчилэн-Булган, Дашинчилэн-Арвайхээр чиглэлийн дамжуулах сүлжээг шилэн кабелиар шинэчилж, Налайх-Багануурын дамжуулах сүлжээг өргөтгөх
- Хотын захын гэр хороолол, дагуул хотуудыг холбоожуулж, интернэтийн сүлжээг өргөтгөх зэрэг асуудлыг шийдвэрлэнэ.

5.2 Дэд бүтэц

Монгол Улсын мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ нь Улаанбаатар хот болон зарим аймгийн төвүүдийг холбосон 2900 км шилэн кабель, 700 гаруй км аналог болон 2900 шахам км тоон технологийн радио релейний шугам, телевиз, радио өргөн нэвтрүүлэг, сансрын холбооны VSAT станцын сүлжээнүүдээс бүрдэж байна. Улаанбаатар хот, 21 аймгийн төв, томоохон хот, суурин газруудад суурин телефоны 146 214, хөдөлгөөнт телефоны 450 000, интернэтийн 220 000 хэрэглэгч тус тус бүртгэгдэж байна.

Улс хоорондын цахилгаан холбооны сүлжээ нь 100 хувь, хот хоорондын дамжуулах байгууламж үндсэндээ хотын төвийн сүлжээ нь 100 хувь тус тус тоон технологид шилжсэн бөгөөд цахилгаан холбооны үйлчилгээг Монголын цахилгаан холбоо ХК, Төмөр замын хэрэг эрхлэх газар, Мобиком, Скайтел зэрэг компаниуд явуулж чөлөөт өрсөлдөөнд орсноор үнэ тариф 3-4 дахин хямдраад байна.

2004 оны 12 дугаар сарын байдлаар улсын хэмжээгээр дундаж 100 хүнд 6.4 суурин, 18.4 хөдөлгөөнт телефон цэг тус тус ноогдож байна.

2001 онд Монгол Улсын 1050 багийг сум, аймгийн төвтэй холбосон тусгай зориулалтын радио холбооны сүлжээг байгуулж эмнэлгийн тургэн тусламж дуудах, байгалийн хүндрэл бэрхшээл тохиолдох, гэнэтийн осол болох зэрэг үед ашиглаж байна.

Монголын Телевизийн өргөн нэвтрүүлгийг сансрын ИНТЕЛСАТ хиймэл дагуулын тусламжтай хот, орон нутагт дамжуулж байна. 2004 онд сансрын телевизийн дамжуулах байгууламжийг тоон системд шилжүүлснээр төлбөрийн хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр 4 телевизийн нэвтрүүлэг дамжуулах техникийн боломжийг бүрдүүллээ.

Улаанбаатар хот, аймгийн төвүүд, томоохон хот, суурин газарт кабель болон MMDS технологи ашиглан нийт 14 аж ахуйн нэгж кабелийн телевизийн сүлжээ ажиллуулж байна. Улсын хэмжээнд кабелийн телевизтэй өрхийн тоо 50000 гаруй болоод байна.

Аймгийн төв болон суурин газруудад радио өргөн нэвтрүүлгийн станц 37 ажиллаж байгаагаас хэт богино долгионы (FM) нэвтрүүлэх станц 26-г дотоодын хөрөнгө оруулалтаар ашиглалтад оруулаад байна. Улаанбаатар, Алтай, Мөрөн хотуудад богино долгионы радио нэвтрүүлэх станцыг 2003 онд ашиглалтад оруулснаар орон даяар 2 программын радио өргөн нэвтрүүлэг сонсох боломжтой болж хамрах хүрээ, хүчин чадлыг нэмэгдүүлж сонгогдсон чанарыг сайжруулласа. Улсын хэмжээнд 2003 оны байдлаар нийт 150000 өрх радиотой гэсэн судалгаа байдаг.

Улаанбаатараас аймгийн төв хүртэл 7 хоногт 2-5 удаа шуудан тээвэрлэж байгаагаас гадна шуудан холбооны уламжлалт болон шинэ төрлийн үйлчилгээг эрхлэн явуулж байна.

5.3. Үйлчилгээ, хэрэглээ Монгол Улсад анх 1994 онд цахим шуудангийн үйлчилгээ, 1996 оноос интернэтийн үйлчилгээ нэвтэрч одоогоор Мэйжикэт, Миком, Бодиком, Эм-Си-Эс, Эрдэмнет, Мобиком, Скай Си энд Си, Рейлком, WiNet зэрэг 9 компани интернэтийн үйлчилгээг эрхэлж байна.

Монголын интернэтийн гадаад гарцын зурвасын өргөн нь одоогийн байдлаар 78 Мб/с, үүнээс хүлээн авах нь 44 Мб/с, дамжуулах нь 34 Мб/с байна.

Төрийн мэдээллийг электрон хэлбэрээр олон нийтэд хүргэх ажил эрчимтэй явагдаж байна. Үүний нэг жишээ бол Монгол Улсын Төрийн байгууллагуудын вэб хуудас www.pmis.gov.mn, Ерөнхий сайдын ажлын албаны www.open-government.mn вэб хуудсууд юм. Монгол агуулга бүхий вэб хуудсууд нь .mn болон бусад домэйн (.com, .org, .net... г.м) нэрээр интернэтэд байрлаж байна. Судалгаагаар идэвхтэй ажиллаж буй 1 500 гаруй монгол вэб сайт байгаагаас 73.6 хувь нь ".mn" домэйн нэрийн дор дотоодын интернэтийн үйлчилгээ үзүүлэгчдийн вэб сервер дээр байрлаж байна. Нийт вэб сайтуудын 50.4 хувь нь хувийн хэвшлийнхэнд, 30.7 хувь нь төрийн бус байгууллагуудад, 9.8 хувь нь хувь хүмүүст, 9.1 хувь нь төрийн байгууллагуудад ногдож байна.

"Мэдээллийн технологийн үндэсний парк"-ийг БНСУ-ын Засгийн газрын тусламжийн хөрөнгөөр байгуулж, 2003 онд ашиглалтад бүрэн оруулласа. Уг парк нь аж ахуйн нэгжийг шалгаруулан мэдээллийн технологийн инкубаторын үйлчилгээнд хамруулж байна. Инкубаторт байрлах аж ахуйн нэгж нь үнэ төлбөргүй байраар хангагдах, интернэтийн нэгдсэн холболтын төлбөрөөс 70 хувь хөнгөлөлт эдлэх, паркийн зүгээс менежментийн их бүрэн дэмжлэг авах зэрэг боломжтой боллоо. Үүний үр дүнд программ хангамжийн чиглэлээр 100 гаруй компани үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдгээрийн бүтээгдэхүүний нэр төрөл, чанар эрс сайжирч байна.

Монгол Улсад цахим-арилжаа, цахим-банкны чиглэлээр сүүлийн жилүүдэд тодорхой дэвшил гарч байна. Арилжааны банкууд картын системийг үйлчилгээндээ нэвтрүүлсэн нь э-арилжаа, э-бизнесийн орон зайн хөгжилд түлхэц үзүүллээ. Одоогийн байдлаар 300 гаруй дэлгүүр, зочид буудал, ресторан, томоохон үйлчилгээний газрууд, шатахуун түгээх төв, аялал жуулчлал, онгоцны тийзийн газруудад зээлийн болон дебет картны үйлчилгээ нэвтрээд байна.

5.4 Хүний нөөцийн хөгжил Өнөөдөр МХХТ-ийн салбарт мэргэжилтэн бэлтгэдэг 12 их, дээд сургууль, коллежид 3000 гаруй оюутан суралцаж, компьютерийн программ болон техник хангамж, мэдээллийн систем, мэдээллийн системийн менежмент, мэдээллийн сүлжээ, цахилгаан болон радио холбоо, телевизийн техник, мэдээллийн технологи гэсэн мэргэжлээр сургалт явуулж бакалавр, магистр, докторын зэрэгтэй мэргэжилтэн бэлтгэж байна. Дээрх сургуулиудыг холбооны инженер мэргэжлээр 1600 гаруй, компьютерийн программ болон техник хангамжийн мэргэжлээр 1500 гаруй хүн төгссөн байна. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газраас өндөр хөгжилтэй орнуудад МХХТ-ийн чиглэлээр магистрантур, докторантурт оюутан суралцах бодлогыг түлхүү баримталж байна.

Мэдээллийн технологийн үндэсний паркийг байгуулснаар мэдээллийн технологийг улс орны хөгжлийн тэргүүлэх чиглэл болгох зорилтыг хэрэгжүүлэх, далхий дахинд өрсөлдөх чадвартай салбар болгон хөгжүүлэх, мэдээлэл, холбооны технологийн талаар төрөөс баримталж байгаа хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх боломж бүрдэх юм. "Мэдээллийн технологийн парк байгуулах", "Мэдээллийн технологийн сургалтын төв байгуулах" зэрэг чухал зорилт хэрэгжлээ.2002 онд Холбоо мэдээллийн сургалтын төвийг байгуулан ажиллуулснаар мэдээллийн технологийн боловсон хүчнийг сургах, давтан сургах чадавхийг бүрдүүлэхэд ихээхэн ач холбогдолтой алхам болж байна.

Түүнчлэн программчлал, интернэт, мэдээллийн сүлжээ зэрэг чиглэлээр Cisco, Microsoft, Sun Microsystems компаниудын итгэмжлэгдсэн урт, богино хугацааны сургалтуудыг явуулж байна.

6. Хөтөлбөрийн хамрах хүрээ

МХХТ-ийг дунд хугацаанд хөгжүүлэхэд дараахь чиглэлийг баримталж байна. Үүнд:

1. Хууль эрх зүй, бодлого, зохицуулалтын таатай орчинг бүрдүүлэх
2. МХХТ-ийн дэд бүтцийг хөгжүүлэх
3. МХХТ-ийг засагчлал болон бусад салбарт хэрэглэх эдийн засаг, бизнесийн орчин, бусад хэрэглээг бүрдүүлэх

LIVEWORKSHEETS

4. МХХТ-ийг эрчимтэй хэрэглэх хүний нөөцийг хөгжүүлэх

Дээрх чиглэлийн дагуу "Цахим Монгол" хөтөлбөрийг дараахь үндсэн стратегид хуваан үзэж болно:

	МХХТ-ийн хөгжлийн зорилт	"Цахим Монгол" хөтөлбөрийн МХХТ-ийн хөгжлийн стратеги
	Хууль эрх зүй, бодлого, зохицуулалтын таатай орчинг бүрдүүлэх	1.1 МХХТ-ийг хөгжүүлэх хууль эрх зүйн шинэтгэл хийх 1.2 Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг бүрдүүлэх 1.3 Цахилгаан холбооны салбарыг либеральчлах
	МХХТ-ийн дэд бүтцийг хөгжүүлэх	2.1 Мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийг хөгжүүлэх 2.2 Хүртээмжтэй, хямд мэдээлэл, холбооны үйлчилгээг хөгжүүлж тоон ялгааг арилгах 2.3 Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээ, санг байгуулах 2.4 Бүх нийтийг компьютержүүлэх 2.5 Мэдээллийн аюулгүй байдлыг хангах
	МХХТ-ийг нийтийн бүх салбарт хэрэглэх	3.1 Төрийн дэмжлэг, манлайллаар хангах 3.2 МХХТ-ийг ашиглан төрийн удирдлагын үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх, шинэчлэл хийх
		МХХТ-ийн хэрэглээ(application), түүний харилцан уялдаа 3.3 Цахим засаглалыг хөгжүүлэх 3.4 Цахим боловсролыг хөгжүүлэх 3.5 Цахим эрүүл мэндийг хөгжүүлэх 3.6 Цахим арилжааг хөгжүүлэх 3.7 Стандарт
		МХХТ-д тулгуурласан эдийн засгийн өсөлт 3.8 Эдийн засгийн салбарт МХХТ-ийн хөрөнгө оруулалт болон хэрэглээг хурдасгах, дэмжих 3.9 Жижиг, дунд үйлдвэр болон аж ахуйн нэгжүүдэд МХХТ-ийн хэрэглээг нэмэгдүүлэх, дэмжих 3.10 МХХТ-ийн дотоодын ажил, үйлчилгээний зах зээлийг хөгжүүлэх 3.11 МХХТ-ийн дотоодын компаниудын экспортын бүтээгдэхүүний өсөлтийг нэмэгдүүлэх
		МХХТ-ийг олон нийтэд таниулах, иргэдийн оролцоо 3.12 Олон нийтэд МХХТ-ийг танин мэдүүлэх 3.13 Олон нийтийг хамарсан сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг эрчимжүүлэх 3.14 Төр засгийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх
	Хүний нөөцийг хөгжүүлэх	МХХТ-ийг ашиглах чадвар, хүний нөөцийн хөгжил 1.1. Хүн бүрт МХХТ-ийг эзэмшүүлэх, дадал олгох 1.2. Төрийн албан хаагчдын МХХТ-ийн боловсролыг дээшлүүлэх 1.3. МХХТ-ийн мэргэшлийн мэргэжилтэн, судлаачид бэлтгэх

7. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Цахим Монгол хөтөлбөрийн МХХТ-ийн хөгжлийн стратегийн үндсэн чиглэлүүдийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, гарах үр дүн, авах арга хэмжээ, хариуцах байгууллага:

7.1 Хууль эрх зүй, бодлого зохицуулалтын орчин

Хэрэгжүүлэх стратеги	Гарах үр дүн	Авах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах байгууллага
1. МХХТ-ийг хөгжүүлэх хууль эрх зүйн шинэтгэл хийх	МХХТ-ийн багц хууль батлагдан гарч МХХТ-ийн хөгжлийн таатай орчин бүрдэнэ Цахим засаглал хөтөлбөрийн бодлого тодорхой болно МХХТ-ийг ашиглан иргэдэд үзүүлэх төр засгийн үйлчилгээг онлайн хэлбэрт оруулснаар иргэдийн 30% энэ үйлчилгээг хүртэнэ Цахим арилжааны үндэсний эдийн засагт эзлэх хувь 10%-д хүрнэ	1) Мэдээллийн технологийн багц хуулийн төслийг боловсруулах 2) Мэдээллийн технологийн багц хуулийг УИХ-аар батлуулах 1) Үүнтэй уялдуулан дагаж мөрдөж байгаа хууль тогтоомжид холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах 2) Цахим арилжаатай холбоотой хууль, тогтоомжид нэмэлт өөрчлөлтүүдийг оруулах	2005-2006 2006 2005-2006 2006-2007	ХЗДХЯ, МХХТГ, ХХЗХ

LIVEWORKSHEETS

2. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг (БНҮҮС) бүрдүүлэх Тайлбар: МХХТ-ийн үйлчилгээ хүргэхэд бизнесийн ашиггүй, хүндрэлтэй алслагдсан хөдөө орон нутгийн хүн амд бүх нийтийн үйлчилгээг үзүүлэхэд зориулагдсан сан болно.	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг бүрдүүлэх үйл ажиллагааг ойлгомжтой болгож тушаалтын төслүүд хэрэгжинэ Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн санхүүжилтээр хөдөөгийн нийт хүн амд үзүүлэх МХХТ-ийн үйлчилгээ 50 хүртэл хувиар нэмэгдэнэ	1) Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг бүрдүүлэх ажиллагааг боловсронгуй болгох 2) Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх 3) Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хэрэгжилтийг зохион байгуулах	2005-2006 2005-2006 2006	СЯ, ХЗДХЯ, МХХТГ, ХХЗХ
3. Цахилгаан холбооны салбарыг либеральчлах	Цахилгаан холбооны салбар хувьчлагдана	1) Цахилгаан холбооны салбарыг либеральчлах хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх 2) Холбогдох хууль, тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах 3) Цахилгаан холбооны салбарын хувьчлалыг хийх	2005-2006 2006 2005-2006	СЯ, ХЗДХЯ, ТӨХ, МХХТГ, ХХЗХ

7.2 Мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтэц

Хэрэгжүүлэх стратеги	Гарах үр дүн	Авах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах байгууллага
1.Мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийг хөгжүүлэх Тайлбар: Өндөр хурдны сүлжээг байгуулахдаа бусад дэд бүтэцтэй уялдуулан хөгжүүлэхэд анхаарах, тухайлбал цахилгаан дамжуулах агаарын шугамын трассын дагуу OPGW төрлийн шилэн кабелийг ашиглах боломжийг судлах	· Бүх аймгийн төвүүд өндөр хурдны сүлжээнд холбогдоно · Бүх сум, суурин газрууд тоон сүлжээнд холбогдоно - Сумдын 30% шилэн кабелийн сүлжээнд холбогдоно - Сумдын 60% утасгүй тоон системд холбогдоно - Сумдын 5% сансрын холбоогоор холбогдоно	1) Суурь сүлжээнд тулгуурлан IP протоколд суурилсан мэдээлэл, харилцаа холбооны үндсэн сүлжээг байгуулах 2) ОХУ, БНХАУ-тай холбогдсон олон улсын өндөр хурдны өргөн зурвасын (broadband) мэдээлэл холбооны газрын сүлжээ байгуулах 3) МХХТ-ийн дэд бүтцэд хувийн хэвшлийн өрсөлдөөнийг нэмэгдүүлэх 4) Төрийн эзэмшилд байгаа болон төрийн өмч давамгайлсан мэдээлэл холбооны үндсэн сүлжээнд тулгуурласан үйлчилгээний бизнесийг үе шаттайгаар хувьчлах 5) Мэдээлэл холбооны сүлжээнд нээлттэй, ялгаваргүй холбогдох, шударга өрсөлдөөний зохицуулалт бүхий зах зээлийн орчинг бүрдүүлэх 6) Улсын нэгдсэн сүлжээг ашиглах, туршлэхтэй холбогдсон харилцаанд байгаа зарим монополь байдлыг халж чөлөөт өрсөлдөөнийг нэвтрүүлэх 7) Дэлхийн хөгжлийн чиг хандлагатай уялдсан хамгийн орчин үеийн утасгүй мэдээлэл холбооны дэвшилтэт технологи болон үүрэн телефоны дараагийн үеийг нэвтрүүлэх Телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлж телевизийн олон сувгийг орон даяар хүлээн авах боломжийг бүрдүүлэх	2006-2012 2005-2007 2005-2010 2005-2008 2005-2006 2005-2006 2006-2010 2005-2012	СЯ, УМХГ, МХХТГ, ХХЗХ, МЦХХК
2.Хүртээмжтэй, хямд, найдвартай холбооны үйлчилгээг хөгжүүлж тоон ялгааг арилгах	· 100 хүнд ноогдох телефон утасны нягтралаар Ази тивдээ эхний аравт орно · Орон нутагт телефон цэгийн нягтрал 15%-д хүрнэ · 2012 он гэхэд бүх аймаг, сум интернэт холболттой болно · Сумдын 65%-д хөдөлгөөнт холбооны үйлчилгээ нэвтэрнэ	1) Хөдөөгийн иргэдэд хүрэх МХХТ-ийн үйлчилгээг түргэн шуурхай хямд үнээр хүргэх дэвшилтэт технологийг нэвтрүүлэх 2) Зарим радио давтамжийн зурвасыг тусгай зөвшөөрөлгүй болгох 3) Харилцаа холбооны салбарыг сүлжээний болон үйлчилгээний чиглэлээр салгаж бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх 4) Малчдад мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг хүргэх арга хэмжээг хэрэгжүүлэх 5) Гэрийн эзэгтэй, өрх толгойлсон эмэгтэйчүүд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан МХХТ-ийн үнэ төлбөргүй сургалтыг зохион байгуулах, энэ чиглэлээр тусгай хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх 6) Ядуурал, ажилгүйдлийг бууруулах, амьжиргааны тогтмол эх үүсвэртэй болоход мэдээллийн технологийг өргөнөөр ашиглах, бага орлоготой өрхийг компьютержүүлэх	2006-2012 2007-2010 2005-2009 2006-2012 2006-2008 2006-2008	СЯ, ХХААЯ, НХХЯ, МХХТГ, УМХГ, ХХЗХ, МЦХХК

LIVEWORKSHEETS

3.Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээ, санг байгуулах Тайлбар: Төрийн өндөр хурдны мэдээллийн сүлжээ нь Цахим засаглал хөтөлбөрийн хэрэглээнүүдийг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлнэ	Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээ,сан байгуулагдана Өндөр хурдны мэдээлэл холбооны хотын сүлжээ байгуулагдана	1) Төрийн өндөр хурдны мэдээллийн сүлжээг байгуулж Улаанбаатар хотын болон үндэсний сүлжээнд холбох 2) Томоохон хот суурин газруудад төрийн болон ТББ, хувийн хэвшлийг холбосон өндөр хурдны сүлжээ байгуулах 3) Төрийн байгууллагуудын мэдээллийн нэгдсэн санг байгуулах	2007-2008 2005-2010 2007-2010	СЯ, МХХТГ, ХХЗХ, УМХГ, ТХГ, МЦХХК
4.Бүх нийтийг компьютержүүлэх	2012 онд 6-гаас дээш насны нийт хүн амын 80% компьютер ашиглах чадвартай болно 2012 онд дунд сургуулийн 10 хүүхэд тутмын нэг нь компьютер ашиглах болно 2012 он гэхэд багш бүр компьютертэй болно 2012 онд бүх сумдын 70%, бүх аймгууд зайны сургалтад хамрагдах болно	1) Бүх нийтийн компьютержүүлэлт төслийг хэрэгжүүлэх 2) Импортоор оруулж ирэх компьютер, түүний дагалдах техник, хэрэгслүүдийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тааламжтай нөхцөлийг бий болгох 3) Дотоодод компьютер үйлдвэрлэх, угсрах, засварлах үйл ажиллагааг дэмжих 4) Иргэд,байгууллагуудад компьютер, техник хэрэгслийг хөнгөлөлттэй нөхцөлөөр худалдах, зээлийн эргэн төлөх хувилбаруудыг банк санхүүгийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх 5) Хэрэглээнийхээ шаардлагаас хамааруулан техник хэрэгслээ сайжруулж буй иргэн, байгууллагуудтай гэрээ хийж, сольж байгаа техник хэрэгслийг нь шилжүүлэн хэрэглэх зарчмыг баримтлах 6) Сургуулийн өмнөх насны хүүхдэд зориулсан компьютержүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх	2005-2008 2005-2006 2006-2007 2005-2006 2006-2008 2006-2008	СЯ, Монгол банк, МХХТГ, ТЕГ, УГЕГ, МТЗ, МХАҮТ, ҮСГ, нийслэл, аймгийн ЗДТГ, ХЭАХХ
5. Мэдээллийн аюулгүй байдлыг/МАБ/ хангах	Хууль эрх зүйн таатай орчин бий болно МАБ-ын бодлого тодорхойлогдоно МАБ-ын стандартууд батлагдана МАБ-ын технологийн орчин бүрдэнэ Иргэд цахим орчны талаар итгэлтэй болно	1) Цахим мэдээлэл солилцох, санхүүгийн гүйлгээ хийх эрэг сүлжээгээр дамжих иргэд, байгууллага хоорондын харилцааны аюулгүй байдал, харилцан итгэлцлийг хангахын тулд эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох 2) Мэдээлэл алдагдах, мэдээллийг өөрчлөхөөс хамгаалсан хууль, эрх зүйг боловсронгуй болгох 3) МАБ-ыг хангах бодлого боловсруулах 4) Мэдээллийн нууцлалаас хамааруулан хамгаалалтын түвшинг (security level of protection) тогтоох 5) Мэдээллийн аюулгүй байдлын технологийн үндэсний стандартыг (infor mation security technology standartization) боловсруулах 6) МАБ-ыг хангах нууцлал (cryptography), хамгаалах болон хяналтын систем (firewall, intrusion detection), программ хангамж, техник хэрэгслийн үнэлгээ хийх 7) МАБ-ыг хангах, кибер довтолгоонтой тэмцэх хамтын ажиллагааг хөгжүүлэх 8) МАБ-ын талаар олон нийтэд өргөнөөр сурталчлах 9) МАБ-ын зөвлөх үйлчилгээг нэвтрүүлэх	2006-2008 2006-2007 2006-2008 2006-2008 2006-2008 2006-2008 2006-2008 2006-2008 2006-2008	ХЗДХЯ, МХХТГ, ТЕГ, ТХГ

7.3 Манлайлал, шинэчлэл

Хэрэгжүүлэх стратеги	Гарах үр дүн	Авах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах байгуулага

LIVEWORKSHEETS

1.Төрийн дэмжлэг, мөнгөлөлтөр хангах	Яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт МХХТ-ийн асуудал хариуцсан мэдээллийн удирдах ажилтан (бүтэц)-тай болно. МХХТ –ийн бодлогын хэрэгжилтийг хангах боломжоо бүрдэнэ	1) Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан МХХТ-ийн бодлого боловсруулах 2) МХХТ-ийн бодлого хэрэгжилтийн удирдамжаар хангах 3) Төрийн бүх шатны байгууллагад МХХТ-ийн асуудал хариуцсан удирдах ажилтан (бүтэц) томилж, МХХТ-ийг хөгжүүлэх нэгдсэн бодлогын хүрээнд салбар хоорондын ажлын уялдааг сайжруулах 4) Засгийн газарт МХХТ-ийн бодлогын зөвлөмж өгөх чиг үүрэг бүхий Ерөнхий сайдаар ахлуулсан орон тооны бус МХХТ-ийн Үндэсний хороог ажиллуулах 5) Үндэсний хэмжээний хэлэлцүүлгийг бий болгож, олон нийтийг бодлого, хэрэгжилтэд оролцох боломжоор бүрдүүлэх 6) Хэрэгжүүлэх стратеги бүрийн зорилго, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах	2006-2007 2006-2007 2006 2006 2006 2006	Яам, агентлаг, МХХТГ, МХХТ-ийн холбоод
2. МХХТ-ийг ашиглан төрийн удирдлагын үйл ажиллагааны ур дүнг нэмэгдүүлэх, шинэчлэл хийх	Төрийн байгууллагуудад МХХТ-ийг нэвтрүүлэх үүрэг бүхий бүтэц бий болно Засгийн газраас МХХТ-ийг ашигласан ажил хэргийн үйл явцын шинэ хэлбэр, загварыг бий болгож, хэрэгжүүлнэ Төрийн ажилтнуудын МХХТ-ийг ажлын байрандаа ашиглах хандлагад өөрчлөлт орно	1) Төрийн удирдлага, үйл ажиллагааны шинэчлэлтийг хэрэгжүүлэх хөрөө байгуулах 2) Шинэчлэлтийн талаар заавар, санал зөвлөмж өгөх дэд хороог байгуулах 3) Шинэчлэлтийн хэрэгжилтийг хянах дэд хороог байгуулах 4) Шинэчлэлтийн хэрэгжилтийг цаг хугацаа, хэмжих аргачлалын дагуу захирамж удирдамжаар хангах	2006 2006 2006 2006	Яам, агентлаг, МХХТГ

7.4. МХХТ-ийн хэрэглээ, түүний харилцан уялдаа

Хэрэгжүүлэх стратеги	Гарах үр дүн	Авах арга хэмжээ	Хэрэгжүүлэх Хугацаа	Хариуцах байгууллага
1. Цахим засаглалыг хөгжүүлэх Тайлбар: МХХТ-ийг ашиглан төрөөс үзүүлэх үйлчилгээний чанар, үр өгөөж, хүртээмжийг дээшлүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох, түүний ил тод, найдвартай, шуурхай байдлыг хангах, авилгал, хүнд суртлыг арилгах боломж бүхий иргэн төвтэй, ур дүнд чиглэсэн засаглалын бүтэц, тогтолцоо, үйл ажиллагааны зарчмуудыг бүрдүүлнэ	МХХТ-ийг ашиглан төрийн төв болон орон нутгийн байгууллагаас иргэд, олон нийт, аж ахуйн нэгж, байгууллагуудад үзүүлэх үйлчилгээг боловсронгуй болгож, 2012 онд төрийн үйлчилгээний 70-аас доошгүй хувийг онлайн хэлбэрт оруулна. Төрийн интранет портал нь иргэдэд орон зай, цаг хугацаанаас үл хамаарсан төрийн мэдээлэл үйлчилгээгээр тасралтгүй хангана. Нэгдсэн кодчиплэн систем, шуудангийн нэгдмэл хаяг бий болгосноор байгууллага хоорондын мэдээллийн системийн менежментийн үл ойлголцол арилна. Гаалийн бүрдүүлэлт, татвар төлөх үйл ажиллагаа бүрэн онлайн болно	1) Иргэдэд олон талт хэрэглээний карт (Smart card) олгох замаар хүн амын хаягжилт, бүртгэл, нийтийн үйлчилгээний орчин үеийн тогтолцоог бий болгох 2) Улс орны хэмжээнд нэгдмэл кодчиллыг бий болгосноор мэдээллийн нэгдсэн системийг бүрдүүлэх 3) Төрийн мэдээллийг цахим хэлбэрээр солилцох хууль эрх зүйн орчинг бүрдүүлж, төрийн бүх байгууллагууд домэйн нэр, вэб хуудас, цахим шуудангийн хаягтай болох 4) Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг цахим хэлбэрээр зохицуулах төрийн интранет порталыг бий болгох 5) Гудамж, талбай, албан байгууллага, айл өрх бүрийг хаягжуулж, шуудангийн бүсийн тогтолцоонд шилжүүлэх 6) Төрийн байгууллагууд дотоод үйл ажиллагаандаа бүртгэл, бусад төрлийн мэдээллийн систем ашиглах (Back Office Application) 7) Төрийн үйлчилгээний үр өгөөж, чанар, хүртээмж, шуурхай байдал, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлж цахим-татвар, цахим-гааль, цахим-бичиг хэрэг зэрэг төсөл хэрэгжүүлж бүх салбарыг хамарсан цаасгүй онлайн үйлчилгээ бий болгох 8) Иргэд, хувийн хэвшилд хүртээмжтэй, хандахад хялбар, найдвартай төрийн мэдээллийн нэгдсэн болон төрөлжсөн сан бий болгох замаар төрийн мэдээллийг олон нийтийн хүртээл болгох 9) Олон нийтэд үзүүлэх үйлчилгээг өргөжүүлэх зорилгоор төрийн байгууллага, олон нийтийн байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжих 10) Төрийн сангийн мэдээллийн системийг өргөтгөн төсвийн бүх байгууллагуудыг хамруулах	2007-2012 2006-2008 2006-2008 2007-2010 2006-2008 2008-2010 2006-2008 2007-2010 2006-2008 2006-2008	Яам, агентлаг, МХХТГ, МХХТ-ийн холбоод
2. Цахим боловсролыг хөгжүүлэх	Нийт хүн амын мэдээллийн технологийн боловсролын түвшин дээшлэнэ	1) Цахим боловсролыг хөгжүүлэх удирдлагын тогтолцоо бий болгох - Цахим боловсролыг нэвтрүүлэх зорилгоор боловсролын салбарт	2006-2010 2006-2010 2006-2008	БСШУЯ, СЯ, МХХТГ

LIVEWORKSHEETS

	2012 он гэхэд бүх хот, суурин газраас зайн сургалтанд оролцох боломжтой болно Төрийн бүх шатны албан хаагчид, нийт хүн амын 80-аас доошгүй хувь мэдээлэл холбооны технологийн анхан шатны боловсролтой (ICT literacy) болно	мэдээллийн технологийн чиглэлээр оруулж байгаа хөрөнгө оруулалт, нөөц бололцоог бүрэн дүүрэн ашиглахад чиглэсэн менежментийн шинэ тогтолцоог бий болгох - МХХТ-ийг нэвтрүүлэх замаар боловсролын байгууллагуудын чадавхийг бэхжүүлж суралцагч төвтэй сургалтад шилжих 2) Боловсролын салбарын мэдээллийн дэд бүтцийг хөгжүүлэх - Ерөнхий боловсролын сургуулиудыг хямд тарифаар мэдээлэл, харилцаа холбооны сүлжээнд холбох зохицуулалтын арга хэмжээ авч ерөнхий боловсролын сургуулиудыг интернэт холболттой болгож их, дээд сургуулиудыг өндөр хурдны интернэтэд холбох - Мэдээллийн технологийг сургалтад ашиглах болон цахим сургалтын материал бэлтгэхэд нь зориулан сургууль бүрийг МХХТ-ийн иж бүрэн техник хэрэгслээр хангаж, 2012 он гэхэд ахлах ангийн 10 сурагч тутамд нэг компьютер ногдох хэмжээнд хүргэх - 2012 онд багш бүрийг компьютертэй болгож, түүнээс 10%-ийг нь зөөврийн компьютертэй болгох - Бүх хичээлийн агуулгыг цахим хэлбэрт шилжүүлэх - Цахим номын сан байгуулах 3) Боловсролын салбарын хүний нөөцийн хөгжил - Боловсролын салбарын хүний нөөцийн мэдээллийн технологийн мэдлэг, чадварыг сайжруулах - Мэдээлэл, харилцаа холбооны технологийн чиглэлээр их, дээд сургуульд элсэгчдийн тоог нэмэгдүүлэх, сургалтын чанарыг сайжруулах, салбарын инженер, техникийн ажилтны мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх - МХХТ-ийн эрдмийн зэрэг цолтой (магистр, доктор) мэргэжилтний тоог нэмэгдүүлэх - Сургалтын мультимедиа төвүүдийг байгуулах - Монгол Улсад бүх нийтийн мэдээллийн технологийн боловсролыг хөгжүүлэхэд алсын зайн сургалтын төвүүдийг өргөнөөр ашиглах - МХХТ-ийн боловсролын олон улсын стандартыг нэвтрүүлж, түвшин тогтоох тогтолцоог бий болгох - Дэлхийн программ хангамж болон МХХТ-ийн үйлчилгээний зах зээл дээр амжилт олох чиглэлээр МХХТ-ийн мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх - Их, дээд сургуулиудын сургалтын цахим хөтөлбөр, стандартыг боловсронгуй болгож олон улсын жишигт хүргэх - Монгол Улсад цахим сургалтыг дэлгэрүүлэх зорилгоор загвар Цахим их сургуулийг байгуулах арга хэмжээ авах - Монголд ээмшсэн боловсролыг дэлхийн аль ч улс оронд хүлээн зөвшөөрдөг болгох зорилгоор англи хэлний сургалтад мэдээллийн технологийн арга хэрэгслийг түлхүү ашиглах - МХХТ-ийн чиглэлээр олон улсын түвшинд хүрсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажлууд хийх 4) Бүх нийтийн мэдээллийн технологийн боловсролыг хөгжүүлэх - Олон улсын компьютерийн боловсролын гэрчилгээг (International computer driving license) бүх нийтийн мэдээллийн технологийн боловсролын тогтолцоонд нэвтрүүлэх - Хувийн хэвшлийн зүгээс цахим боловсролын хөгжилд оруулах хөрөнгө оруулалтыг дэмжих, хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээ авах - Технологи судалгаа, шинжилгээний болон хөгжлийн төвийг Мэдээллийн технологийн үндэсний парк болон бусад	2006-2010	

LIVEWORKSHEETS

		мэргэжлийн сургуулиудад түшиглэн байгуулах		
3. Цахим эрүүл мэндийг хөгжүүлэх Тайлбар: Нэгдмэл үйл ажиллагаанд тулгуурласан өвчтөн төвтэй үйлчилгээнд шилжиж иргэдийг цаг хугацаа, орон зайнаас үл хамаарсан хямд, найдвартай үйлчилгээгээр хангана	Өвчний түүх, оношилгоо, шинжилгээний зураг, холбогдох мэдээлэл бүхий мэдээллийн сан үүсгэн цахим мэдээлэл солилцоог дэлгэрүүлнэ Бүх нийтийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд МХХТ-ийг ашиглана Алсын зайн эмчилгээ, оношилгоо, хяналтыг орон нутагт хүргэнэ	1) Өвчний цахим түүхийг бий болгох - Эмнэлэг, өвчтөн, эрүүл мэндийн даатгалыг хамарсан нэгдсэн сүлжээ, өгөгдлийн сан, архив байгуулан цаасгүй эмнэлэг технологид шилжих, цаасан дээр бичиж тэмдэглэх,лабораторийн шинжилгээ, оношилгооны үр дүн, (рентген зураг, компьютерийн томограмм зураг, ЭХО зураг гэх мэт), эмийн сангаас олгосон эм, хийсэн эмчилгээ, мэс ажилбар, хоол, төлбөрийн баримт зэрэг бүх мэдээллийг цахим хэлбэрээр хадгалах (e-medical record) - Эрүүл мэндийн салбарын хэмжээнд МХХТ-ийн удирдлага, бодлого, зохицуулалтын тогтолцоог боловсронгуй болгох, үүнтэй холбогдсон стандартуудыг боловсруулах - Эрүүл мэндийн нэгдсэн сүлжээний мэдээллийн аюулгүй байдлыг хангах, халдлагаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах 2) Хүн амын эрүүл мэндийн боловсрол, эрүүл мэндийн мэдээллийн сан хөгжүүлэх - Иргэдийг эрүүл мэндээ хянах, оношлуулах, зөвлөгөө авах боломжоор хангаж тэдний эрүүл мэндээ хамгаалах идэвхтэй оролцоог дэмжих - Бүх төрлийн эмийн лавлагааг нээлттэй онлайн хэлбэрт оруулах 3) МХХТ-ийн дэвшлийг эрүүл мэндийн салбарт нэвтрүүлэх - Эрүүл мэндийн салбарт цахим төлбөр тооцоог нэвтрүүлэх - Алсын зайн эмчилгээ, оношилгоо, хяналтыг төв суурин газар, орон нутагт нэвтрүүлэх - Гадаадын нэр хүнд бүхий эмнэлгүүдтэй интернэтээр шууд холбогдох онлайн эмнэлэг, оношилгооны бүтцийг бий болгох	2007-2010 2006-2010 2006-2008	ЭМЯ, МХХТГ

LIVEWORKSHEETS

4. Цахим арилжаат хяналт Тайлбар: Цахим арилжааны үндсэн онцлог болох хэрэглэгчдэд бараа, ажил, үйлчилгээг орон зай, цаг хугацаанаас үл хамааран шуурхай арилжих, худалдах, солилцох боломжийг олгодог давуу талыг ашиглан өрсөлдөх чадварыг дээшлүүлж эдийн засгийн шинэ боломж, орчинг бий болгоно Цахим хангамж нь (e-procurement) төрийн үйл ажиллагааны шинэчлэлийн чухал хэсэг юм. Төрөөс бараа, үйлчилгээг худалдан авах зардлыг бууруулж, ил тод, түргэн шуурхай арилжааны орчныг бий болгоно	Монгол Улсад цахим арилжааг нэвтрүүлснээр 2012 он гэхэд бизнес (Business-to-business) хоорондын зах зээлийг өнөөгийн хэмжээнээс 10 дахин, бизнес ба хэрэглэгч (business-to-consumer) хоорондын зах зээл 20 дахин өсне Цахим арилжаа гадаад, дотоод худалдаа, экспорт, импортыг нэмэгдүүлнэ	1) Цахим арилжааны дэд бүтцийг бүрдүүлэх - Цахим арилжаатай холбогдох хууль эрх зүйн орчинг бий болгох, мэдээллийн аюулгүй байдал, цахим гэрээ, цахим гарын үсэг, оролцогч талуудын эрх, үүрэгтэй холбогдсон эрх зүйн баримт бичгүүдэд цахим арилжааны онцлогтой уялдуулан зохих нэмэлт, өөрчлөлтийг оруулах - Иргэд, хуулийн этгээдийн зээлийн түүхийн тогтолцоог бий болгох (Credit History) - Цахим арилжааг дэмжсэн бараа хүргэлтийн сүлжээг бий болгох - Бүх шатны шуудан хүргэлтийн тогтолцоог боловсронгуй болгож, шуудангийн зах зээлийн өрсөлдөөний зохицуулалтын механизмыг бүрдүүлж, шууданд санхүүгийн болон электрон худалдааны үйлчилгээг нэвтрүүлэх 2) Мэдээллийн сан, мэдээллийн удирдлагын систем бий болгох - Аж ахуйн нэгж, байгууллага, - хэрэглэгчдэд нээлттэй, шуурхай үйлчлэх арилжааны мэдээллийн сан бий болгох - Цахим арилжааны мониторингийн тогтолцоог бий болгох - Олон улсын болон банк хоорондын гүйвүүлгыг цахим хэлбэрээр явуулах боломжийг өргөтгөх - Цахим арилжааны бөөний худалдааны сүлжээ бий болгох 3) Олон улсын цахим арилжаанд оролцох - Олон улсын гэрээний дагуу цахим хэлбэрээр хийгдэх арилжааны тогтолцоонд нэгдэн орж, цахим арилжааны чиглэлийн олон улсын байгууллагуудын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох - Хувийн хэвшил,иргэдийг олон улсын цахим арилжаанд оролцоход дэмжлэг үзүүлэх 4) Цахим төлбөрийн аюулгүй байдлыг хангах - Цахим хэлбэрээр хийгдэж байгаа мөнгөн гүйлгээ, төлбөрийн тогтолцооны оновчтой хэрэглээг хэвшүүлэх - Цахим арилжааны аюулгүй байдал, найдвартай ажиллагааны үйлчилгээг хариуцсан итгэмжлэгдсэн бүтцийг бий болгох - Олон нийтийн өгөгдлийн санд МАБ болон хамгаалалтын түвшин тогтоох 5) Цахим арилжааны талаар мэдээллийн чиглэлийн их, дэд сургуулийн сургалтын хөтөлбөрт оруулах 6) Төсвийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах цахим тогтолцоог бий болгох - Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжид холбогдох өөрчлөлт оруулан шударга өрсөлдөөний нөхцөлийг бүрдүүлж зардлыг бууруулах - Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах цахим туршлага судлах, туршилтын төслийг хэрэгжүүлэх - Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах цахим тогтолцооны тендер зарлах, шалгаруулах порталыг бий болгох	2006-2008 2006-2008 2007-2008 2006-2008 2006-2008 2007-2010	СЯ, ҮХЯ, МХХТГ

LIVEWORKSHEETS

5. Харилцан уялдаа, стандарт Тайлбар: Олон улсын жишиг нийцсэн стандартыг баталж мөрдүүлэх, дотоодын зах зээлд зохицсон стандартын хэрэглээг дэмжих	Технологийн хөгжлийн үр дүнг ашиглахын тулд стандартуудыг тогтмол хянах механизмыг хэрэгжүүлнэ	1) Стандартын төсөлд оролцогч талуудаас санал авч боловсруулж мөрдүүлэх, түүний хэрэгжилтэд хяналт тавих 2) Байгууллагууд дотоодын интранет дээр суурилсан дотоод үйл ажиллагаа, зохион байгуулалт, бичиг хэрэг хөтлөлтийн программ хангамжийн стандарт бий болгох 3) МХХТ-ийн хууль бус хэрэглээг илрүүлэн, таслан зогсоох чиглэлээр холбогдох байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулах	2008-2012 2008-2010 2008-2010	СЯ, ЗТАЖЯ, МБ, МХХТГ, СХЗТ, ИБМУТ, ҮСГ

7.5 МХХТ ашиглан эдийн засгийн өсөлтийг хангах

Стратеги	Үр дүн	Хийх ажлууд
1. Эдийн засгийн салбарт МХХТ-ийн хөрөнгө оруулалт болон хэрэглээг хурдасгах, дэмжих	- Цахим зах зээл, мэдээллийн системийн менежмент бий болно - Хэрэглэгчийг үнэн зөв мэдээллээр хангах, мэдээлэл солилцох үйл ажиллагаа хөгжинө	1) МХХТ-ийн чиглэлээр хөрөнгө оруулалт хийх аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх 2) Төвлөрсөн болон төрөлжсөн мэдээллийн сан, мэдээллийн систем болон цахим зах зээлийг (e-marketplace) салбар бүрээр байгуулах, өргөтгөх 3) Хувийн хэвшлийн мэдээллийн хэрэгцээ, шаардлагыг судалж, загвар байгуулагын жишгийг тогтоох
2. Жижиг дунд үйлдвэр (ЖДҮ) болон аж ахуйн нэгжүүдэд МХХТ-ийн хэрэглээг нэмэгдүүлэх, дэмжих.	- МХХТ-ийг ашиглаж байгаа загвар жижиг, дунд үйлдвэр байгуулна - Баг, сум, аймгийн түвшинд олон нийтийн мэдээллийн төвтэй болж тоон ялгаа буурна	1) Эдийн засгийн салбар тус бүрт МХХТ-ийг нэвтрүүлсэн жижиг, дунд үйлдвэрийн жишиг загварыг бий болгож түүний давуу тал, ач холбогдлыг сурталчлах 2) Программ хангамжийн дотоодын зах зээлийг судалж жижиг, дунд үйлдвэрт өргөнөөр хэрэглэх 3) Жижиг, дунд үйлдвэрт зориулсан багц программ хангамжийн зах зээлийг хөгжүүлэх 4) МХХТ–ийн зөвлөгөө өгөх тогтолцоо бий болгож хөгжүүлэх 5) Мэдээллийн технологийн хөтөлбөр боловсруулах, МХХТ-ийг жижиг, дунд үйлдвэрт сурталчлах үйл ажиллагааг дэмжих 6) Автоматжуулсан, компьютержсэн систем, техник, тоног төхөөрөмж, технологид чиглэсэн хөрөнгө оруулалтын бодлогыг дэмжих 7) Экспортод зориулсан дотоодын бараа, үйлчилгээг судалж экспортыг нэмэгдүүлэхийн тулд интернэтийг маркетингийн зорилгоор өргөнөөр ашиглах
3. МХХТ-ийн дотоодын зах зээлийг хөгжүүлэх Тайлбар: МХХТ-ийн шийдэл, үйлчилгээний хэрэгцээг нэмэгдүүлэх	МХХТ-ийн хэрэглээг ашиглан үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлнэ	1) Эрх зүйн таатай орчин бүрдүүлэх /нэмэгдсэн өртгийн алban татвар, орлогын алban татварт өөрчлөлт оруулах/ 2) МХХТ-ийн зөвлөгөө өгөх бүтцийг бий болгох 3) Оюуны багтаамж ихтэй үйлдвэрлэлийн (smart Factory) хөгжлийг дэмжих 4) Цахим зах зээлийн орон зайг (e-market place) МХХТ-ийн компаниудад зориулан бүрдүүлэх 5) Цахим аялал жуулчлал, цахим тээвэр зэрэг төслүүдийг боловсруулж хэрэгжүүлэх
4. МХХТ-ийн дотоодын компаниудын экспортын бүтээгдэхүүний өсөлтийг нэмэгдүүлэх	- МХХТ-ийн компаниудын хүчин чадал бэхжинэ - МХХТ-ийн дотоодын /программ хангамжийн/ компаниудын олон улсын зах зээлд өрөлдөх боломжийг бүрдүүлнэ	1) МХХТ-ийн дотоодын компаниудын өрөлдөх чадвар, гадаад зах зээлийн хэрэгцээг судлах 2) Зах зээлийн урьдчилсан судалгаа гаргах 3) Бизнес стратегийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх 4) Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн инженер бэлтгэх (урт, богино хугацааны сургалт) 5) Программ хангамжийн хөгжлийн үйл ажиллагааг сайжруулах (CMM/ISO сургалт, CMM/ISO хэрэгжилт) 6) Мэдээллийн технологийн паркийн үйл ажиллагааг боловсронгуй болгох 7) Программ хангамжийн үзэсгэлэн худалдаа, семинарыг тогтмол зохион байгуулах 8) Гадаадын зорилтот зах зээлд төлөөлөгчийн газар бий болгох 9) Нээлттэй код бүхий программ хангамжийг (open source) хөгжүүлж, түүнийг хөрвүүлэх (localization) үйл ажиллагааг эрчимжүүлэх 10) Нээлттэй код бүхий программ хангамжийн стандар боловсруулж хэрэглээг бий болгох

7.6 МХХТ-ийг олон нийтэд сурталчлах, төрийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх

Стратеги	Үр дүн	Хийх ажлууд	Хэрэгжүүлэх хугацаа	Оролцох байгууллага

LIVEWORKSHEETS

1. Олон нийтэд МХХТ-ийг сурталчлах	100 хүнд оногдох компьютер хэрэглэгчдийн тоог 20 -д хүргэнэ Олон нийтийн мэдээллийн төвийн үйл ажиллагаа шинэчлэгдэнэ	1) Бүх сумдад олон нийтийн мэдээллийн төвийг шинээр байгуулах 2) Аймгийн төвүүд дэх олон нийтийн мэдээллийн төвийг өргөтгөн шинэчлэх 3) Интернэт холболтын үнийг үе шаттайгаар бууруулах 4) Өндөр хурдны өргөн зурвасын сүлжээг өргөтгөх 5) Олон нийтэд зориулсан интернэт цэгүүдийг онгоц, төмөр замын буудал, авто зогсоол, кино театр зэрэг үйлчилгээний газруудад бий болгох 6) Бүх нийтийн мэдээллийн технологийн боловсролд зориулсан ном, сэтгүүл болон мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагааг дэмжих	2007-2010 2006-2008 2006-2010 2005-2012 2006-2008 2006-2010	МХХТГ, Мэдээллийн технологийн үндэсний парк, Монголын мэдээллийн технологийг хөгжүүлэх холбоо (МИДАС), аймаг, нийслэлийн ЗДТГ
	Вэб хуудсуудын тоо 30000-д хүрнэ mn. өргөтгөлтэй домэйн нэрний үнэ буурна Автомат вэб орчуулагч нийтийн хүртээл болно	1) Шилдэг вэбийг урамшуулах, вэб хуудасны чанарыг сайжруулах 2) .mn домэйн нэрийн үнийг бууруулах, төрийн болон бизнесийн байгууллагуудыг домэйн нэр, вэб хуудастай болгох 3) Гадаад хэл дээрх вэб хуудсыг монгол хэл рүү орчуулах автомат хөрвүүлэх системийг хөгжүүлэх 4) Боловсролын чиглэлийн вэб хуудасны тоог нэмэгдүүлэх	2006-2008 2006-2008 2007-2010 2006-2010	
	Программ хангамжийн чанар сайжирч, хэрэглээ нэмэгдэнэ	5) Хэрэглээний программ хангамжийн уралдаан зохион байгуулах 6) Бүх аймагт мэдээллийн технологийг хөгжүүлэх баг/team/ бүрдүүлж байнгын ажиллагаатай болгох	2006-2010 2006-2008	
	Гарын авлага, ном гаргана	1) МХХТ-ийн нэр томьёоны тайлбар гаргах 2) Ойлгомжтой, хялбаршуулсан тайлбартай номын өргөн хэрэглээг бий болгох 3) МХХТ-ийн үзэсгэлэн, вдеопөгийг Улаанбаатар хот болон аймгуудад зохион байгуулах	2006-2010 2006-2010 2006-2008	
2.Олон нийтийг хамарсан үйл ажиллагааг эрчимжүүлэх	МХХТ-ийг олон нийтэд сурталчлах үндэс тавигдана	1) Компьютер сургалтын интерактив программ хангамжийг хөгжүүлэх 2) МХХТ-ийн хэрэглээний хичээлийг телевизээр нэвтрүүлэх 3) Зөвлөгөө, тусламж, лавлагаа өгөх үйлчилгээг хөгжүүлэх 4) МХХТ-ийн мэдлэг үнэлэмжийг сайжруулах	2006-2008 2006-2008 2006-2010 2006-2010	
3. Тер, засгийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх	МХХТ хөгжөөнөөр дараахь боломж бүрдэнэ: 1) түргэн шуурхай, нээлттэй, найдвартай төрийн үйлчилгээгээр хангагдана 2) хүнд суртал, авилгал буурна 3) төрийн бодлого боловсруулах үйл ажиллагаанд иргэдийн оролцоо нэмэгдэнэ	1) Сонгууль, ард нийтийн санал асуулгад цахим хэлбэрийг ашиглах /бүртгэл, санал өгөх, санал тоолох, ур дүнг тооцох гм./ 2) Нэр дэвшигч,сонгогчдын онлайн мэтгэлцээн, хэлэлцүүлгийг бий болгох 3) Онлайн зөвлөгөө, олон нийтийн форум, хэлэлцүүлэг бий болгох 4) МХХТ-ийг ашиглан бодлого боловсруулах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх 5) Хууль тогтоомжийн төсөлд онлайн хэлэлцүүлгээр дамжуулан олон нийтийн санал авч тусгадаг болох 6) Төрийн байгууллага, албан тушаалтанд хандсан хүсэлт,гомдол, саналыг хүлээн авч шийдвэрлэх цахим тогтолцоог бий болгох	2008-2012 2008-2012 2007-2012 2006-2012 2006-2012 2006-2008	Яам, агентлаг МХХТГ, ТББ, Мэдээллийн технологийн үндэсний парк, Монголын мэдээллийн технологийг хөгжүүлэх холбоо (МИДАС)

7.7. МХХТ-ийг ашиглах чадвар, хүний нөөцийн хөгжил

Хэрэгжүүлэх стратеги	Гарах үр дүн	Авах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах байгууллага

LIVEWORKSHEETS

1. Хүн бүрт МХХТ-ийг эзэмшүүлэх, дадал олгох Тайлбар: Мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцээр хангана. Ерөнхий боловсролын чанар дээшлэх боловсролын салбар дахь өрсөлдөх чадвар нэмэгдэнэ. МХХТ-ийн боловсрол, ур чадвар нэмэгдсэнээр сургалт, заах арга, мэдээлэл солилцоо сайжирна.	Ерөнхий боловсролын болон мэргэжлийн сургуулиудад МХХТ-ийн сургалтын төвүүдийг байгуулж, сургалтын бүх шатанд компьютерийн сургалт бий болно. Эдийн засаг, нийгэм, соёлын бүх салбарт МХХТ-ийн хэрэглээг нэвтрүүлнэ. МХХТ-ийг ашиглах чадвар мэдэгдэхүйц дээшилнэ. Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвүүдийг төгсөгчдийн МХХТ-ийг ашиглах чадварын түвшин дээшилнэ. Насанд хүрэгчдийн МХХТ-ийн боловсрол дээшилнэ. Сургалтын төвүүд ялангуяа орон нутагт ажиллаж байгаа багш нарын МХХТ-ийн мэдлэг чадавхи дээшилнэ.	1) Ерөнхий боловсролын болон Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийг мэдээллийн технологийн орчин үеийн техник технологиор, багшлах хүний нөөцөөр хангах 2) Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сургалтын программын стандартыг баталгаажуулах, олон улсын компьютер хэрэглэгчийн лиценз /ICDL гэх мэт /, стандартыг нэвтрүүлэх 3) Олон нийтийн хэрэгцээг судлан үзэх, орон нутгийн захиргааны байгууллагын сургалтын хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох 4) Олон нийтийн МХХТ-ийн хэрэглээг дэмжих зорилгоор сургалт, семинар зохион байгуулах 5) Сургууль, номын сан, шуудан холбоо, теле-төвүүдэд шинэ технологийг нэвтрүүлэх 6) Нийгмийн бүх давхарга ялангуяа эмэгэг бүлгийнхэнд мэдлэг олгох, мэдээлэл түгээх зорилгоор алсын зайн сургалт, цахим сургалтыг (e-learning) дэмжин хөгжүүлэх 7) Багш, сургагч-багш бэлтгэх, давтан сургах, тэдний мэргэжлийн ур чадварыг дээшлүүлж, сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох 8) Багшлах хүний нөөцийг хөгжүүлэх зайн сургалтад МХХТ-ийг өргөнөөр ашиглах 9) Багш дутагдалтай байгаа орон нутагт гадаад, дотоодын мэргэшсэн сайн дурын багш нарыг урьж ажиллуулах 10) Залуу үеийг мэдээлэл харилцаа холбооны шинэ үеийн техник, технологийг ашиглах нөхцөлөөр хангах	2007-2010 2006-2012 2006-2008 2006-2008 2007-2012 2007-2012 2006-2010 2007-2010 2008-2012 2006-2010	БСШУЯ, МХХТГ, хандивлагчид, орон нутгийн удирдлага, Стандартчилал, хэмжил зүйн төв, ТББ
2. Төрийн албан хаагчдын МХХТ-ийн боловсролыг дээшлүүлэх	Төрийн албан хаагчид МХХТ ашиглаж ажил үүргээ гүйцэтгэснээр төрийн үйлчилгээний чанар сайжирч үйл ажиллагаа нь ил тод болно. Төрийн байгууллага мэдээллийн технологи болон компьютер ашиглах чадвар бүхий бэлтгэгдсэн ажилтнаар хангагдана.	1) Төрийн байгууллагын ажилтнуудыг компьютерийн болон МХХТ-ийн сургалтад хамруулах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх 2) Ажлын байрны зах зээлийн хэрэгцээ шаардлага, МХХТ-ийн хөгжлийн түвшинтэй уялдуулан техник, программ хангамжийн шинэчлэлийг үе шаттайгаар хийх 3) Төрийн албаны шалгаруултад МХХТ-ийг ашиглах чадварыг гол үзүүлэлтийн нэг болгох 4) Төрийн албан хаагчдын МХХТ-ийн мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд зайн болон цахим сургалтыг өргөнөөр ашиглах	2006-2008 2007-2012 2007-2012 2007-2012	БСШУЯ, ТАЗ, МХХТГ, их, дээд сургуулиуд
3. МХХТ-ийн чиглэлээр мэргэшсэн мэргэжилтэн, судлаачид бэлтгэх МХХТ-ийн чиглэлийн тухайн салбарын сургалт болон мэргэжлийн их, дээд сургууль байгуулахад хувийн хэвшлээс оруулах хөрөнгө оруулалтыг дэмжинэ.	Мэргэшсэн мэргэжилтэн, судлаачдыг сургах хөтөлбөр хэрэгжинэ. Мультимедиа төвүүдийг аймаг орон нутгийн түвшинд байгуулан чадварлаг хүний нөөц бий болно.	1) Мэргэшсэн мэргэжилтэн, судлаачдыг урт хугацаанд тогтвортой бэлтгэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх 2) 1000 залуу мэргэжилтэн, судлаачдыг өндөр хөгжилтэй оронд суралцуулах 3) МХХТ-ийн зах зээлд эрэлт шаардлагатай мэргэжилтэн бэлтгэх 4) МХХТ-ийн хэрэгцээ шаардлагад нийцсэн мэргэжлийн судалгаа, хөгжлийн төв байгуулах 5) Гадаадын нэр хүндтэй их, дээд сургууль, бусад мэргэжлийн байгууллагатай холбоо тогтоон эрдэм шинжилгээ судалгааны хамтын ажиллагааг хөгжүүлэх	2007-2012 2008-2012 2006-2010 2007-2012 2008-2012	БСШУЯ, МХХТГ, их, дээд сургууль, ТББ, МТ-ийн компаниуд

Удирдлага, хяналт-шинжилгээ, үнэлгээ

"Цахим Монгол" хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, хяналт-шинжилгээ хийх үүргийг Монголын Мэдээлэл, холбооны технологийн Үндэсний хороо хэрэгжүүлнэ.

Үндэсний хороо нь хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, шинжилгээ, үнэлгээг хийхийн зэрэгцээ хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулна.

Хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэр

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нийт 134 384 000 000 төгрөг дараахь эх үүсвэрээс зарцуулахаар төлөвлөж байна.

(төгрөгөөр)

Улсын төлөрсөн төсвөөс 26 000 000 000

Орон нутгийн төсвөөс 16 000 000

Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, зээл,

тусламж..... 85 800 000 000

Бүх нийтийн үүргийн сангаас.....3 000 000 000

LIVEWORKSHEETS

Иргэний нийгмийн санаачилга, аж ахуйн нэгж, байгууллагын хандив, тусламж 1 000 000 000

Хувийн хэвшлээс 18 568 000 000

Хөрөнгө оруулалтын арга хэмжээ, төсөв

	"Цахим Монгол" хөтөлбөрийн МХХТ-ийн хөгжлийн стратеги	Авах арга хэмжээ	Урьдчилсан байдлаар шаардагдах хөрөнгө /сая төгрөг/	Хөрөнгийн эх үүсвэр
	Хууль эрх зүй, бодлого зохицуулалт:			
	1.1 МХХТ-ийг хөгжүүлэх хууль эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх		12.0	гадаадын хөрөнгө оруулалт
	1.2 Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг бүрдүүлэх			
	1.3 Цахилгаан холбооны салбарыг либеральчлах			
		Дүн	12.0	
	Мэдээллийн дэд бүтэц			
	2.1 Мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийг хөгжүүлэх	1) ОХУ, БНХАУ-тай холбогдсон олон улсын өндөр хурдны өргөн зурвасын (broadband) мэдээлэл холбооны гаврын сүлжээ байгуулах	12,000.0	хувийн хэвшил
		2) Улаанбаатар хотын өндөр хурдны backbone сүлжээ байгуулах	5,000.0	хувийн хэвшил
		3) Хот хооронд өндөр хурдны сүлжээ байгуулах	30,000.0	төсөв, хувийн хэвшил, гадаадын хөрөнгө оруулалт
	2.2 Хүртээмжтэй,хямд мэдээлэл, холбооны үйлчилгээг хөгжүүлж тоон ялгааг арилгах	1) Хөдөөгийн МХХ-ны сүлжээг бий болгох	20,000.0	төсөв, гадаадын хөрөнгө оруулалт
	2.3 Төрийн мэдээллийн сүлжээ,санг шинэчлэх		5,500.0	гадаадын хөрөнгө оруулалт
	2.4 Ерөнхий боловсролын сургуулийг компьютержүүлэх		10,000.0	төсөв, гадаадын хөрөнгө оруулалт
	2.5 Мэдээллийн аюулгүй байдлыг хангах (PKI)		1,000.0	хувийн хэвшил
		Дүн	83,500.0	
	Мэдлэгжилт, шинэчлэл			
	3.1 Төрийн дэмжлэг мэдлэгжилтээр хангах			
	3.2 МХХТ-ийг ашиглан үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор захиргааны шинэчлэл хийх			
		Дүн		
	МХХТ-ийн хөрөнгө, түүний хүрээлэн үүсгэх			
	4.1 Цахим засаглалыг хөгжүүлэх	1) Иргэдэд олон талт хэрэглээний карт/Smart card/ олгох замаар хүн амын хөгжилт, бүртгэл, нийгмийн үйлчилгээний орчин үеийн тогтолцоог бий болгох	12,000.0	гадаадын хөрөнгө оруулалт
		2) Хүүхдийн эцэгийн болон үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийг МХХТ-ийн дэвшилтэт аргаар бүртгэн шинэчлэх, нийгмийн даатгал, нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэндийн даатгал, орлогын албан татвар, элсэлтийн шалгалт, цэргийн бүртгэл зэргийг хамарсан мэдээллийн нэгдмэл сан байгуулах	6,000.0	гадаадын хөрөнгө оруулалт
		3) Улсын хэмжээнд нэгдмэл кодчиллыг бий болгосноор мэдээллийн нэгдсэн системийг бүрдүүлж,гудамж, талбай, албан байгууллага, айл өрх бүрийг хаяжуулж, шуудангийн бүсийн тогтолцоонд шилжүүлэх	12.0	
		4) Төрийн мэдээллийг цахим хэлбэрээр солилцох хууль эрх зүйн орчинг бүрдүүлж, төрийн бүх байгууллагыг домэйн нэр, вэб хуудас, цахим шуудангийн хаяттай болгох		
		5) Төрийн байгууллагын үйл ажиллагааг цахим хэлбэрээр зохицуулах төрийн интранет порталыг бий болгох	840.0	Гадаадын төсөл
		6) Төрийн байгууллага дотоод үйл ажиллагаандаа бүртгэл, бүсад төрлийн мэдээллийн систем ашиглах (Back Office Application)	1,800.0	Дотоодын төсөл
		7) Төрийн үйлчилгээний үр өгөөж, чанар, хүртээмж, шуурхай байдал, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлж цахим-татвар, цахим-гааль, цахим-бичиг хэрэг зэрэг төсөл хэрэгжүүлж, бүх салбарыг хамарсан цаасгүй онлайн үйлчилгээ бий болгох	6,000.0	Гадаадын төсөл
		8) Төрийн сангийн мэдээллийн системийг өргөтгөн төсвийн бүх байгууллагыг хамруулах	15,000.0	төсөв, гадаадын төсөл
		9) Олон нийтэд үзүүлэх үйлчилгээг өргөжүүлэх зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжих		
		10) Иргэд, хувийн хэвшилд хүртээмжтэй, хандахад хялбар, найдвартай төрийн мэдээллийн нэгдсэн болон тереглэсэн сан бий болгож, төрийн мэдээллийг олон нийтийн хүртээл болгох		
	4.2 Цахим боловсролыг хөгжүүлэх	1) Цахим боловсролыг хөгжүүлэх удирдлагын тогтолцоо /management system/ бий болгох		
		2) Боловсролын салбарын мэдээллийн дэд бүтцийг (Интернэт, боловсролын төлөө суваг) хөгжүүлэх	2,000.0	Гадаадын төсөл
		3) Боловсролын салбарын хүний нөөцийн хөгжил	100.0	Гадаадын төсөл
		4) Бүх нийтийн мэдээллийн технологийн боловсролыг хөгжүүлэх		
	4.3 Цахим эрүүл мэндийг хөгжүүлэх	1) Өвчний цахим түүхийг бий болгох		
		2) Хүн амын эрүүл мэндийн боловсрол, эрүүл мэндийн мэдээллийн сан хөгжүүлэх		
		3) МХХТ-ийн дэвшилтэй эрүүл мэндийн салбарын техник технологийн хөгжилд нэвтрүүлэх	1,200.0	Гадаадын төсөл

LIVEWORKSHEETS

	4.4 Цахим арилжаат хөнгөлөх	1) Цахим арилжааны суурь орчинг бүрдүүлэх		
		2) Мэдээллийн сан болон удирдлагын систем /management system/ бий болгох		
		3) Олон улсын цахим арилжаанд оролцох		
		4) Цахим төлбөрийн аюулгүй байдлыг хангах		
		5) Хуний нөөцийг хөнгөлөх		
		6) Мэдээллийн дэд бүтцийг байгуулах		
	4.5 Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах цахим тогтолцоог бий болгох		200.0	төсөв
		Дүн	45,152.0	
	МХХТ ашиглан эдийн засгийн өсөлтийг хангах			
	5.1 Жижиг, дунд үйлдвэр болон аж ахуйн нэгжүүдэд МХХТ-ийн хэрэглээг нэмэгдүүлэх, дэмжих			
	5.2 Эдийн засгийн салбарт МХХТ-ийн хөрөнгө оруулалт болон хэрэглээг хурдасгах, дэмжих			
	5.3 Дотоодын МХХТ-ийн зах зээлийг хөнгөлөх			
	5.4 Дотоодын МХХТ-ийн компаниудын экспортын бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх			
		Дүн		
	МХХТ-ийг олон нийтэд сурталчлах, төр, засгийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх			
	6.1 Олон нийтэд МХХТ-ийг сурталчлах	1) Сумдад мэдээллийн нөгдмөл төвүүдийг байгуулах	960.0	Гадаадын төсөл
		2) Аймгийн төвийн олон нийтийн мэдээллийн төвийг өргөтгөх	480.0	Гадаадын төсөл
		3) Интернэт холболтын үнийг бууруулах		
		4) Олон нийтэд зориулсан интернэт цэгүүдийг онгоцны болон төмөр замын буудал, авто зогсоол, кино театр зэрэг үйлчилгээний газруудад бий болгох	600.0	хувийн хэвшил
		5) Шилдэг вэб хуудсыг урамшуулах		
		6) Вэб хуудасны хөгжлийг хялбар болгож идэвхжилийг өсгөх		
		7) .mn домэйн нэрийн үнийг бууруулах, хувийн болон албаны домэйн нэр, вэб хуудастай болгох		
		8) Гадаад хэл дээрх вэб хуудсыг монгол хэл рүү хөрвүүлэх орчуулгын системийг дэмжих		
		9) Боловсролын чиглэлийн вэб хуудас хэрэглэх үйл ажиллагааг дэмжих		
		10) Нийтэд танигдсан вэб хуудсын мэдээллийг орчуулах		
		11) МХХТ-ийн нэр томьёоны тайлбар, лавлагаа бий болгох		
		12) Хэрэглэгчдэд ойлгомжтой, энгийн, хялбаршуулсан тайлбартай номыг дэмжих (Dummies)		
		13) МХХТ-ийн үзэсгэлэн, өдөрлөгийг Улаанбаатар хот болон орон нутагт тогтмол зохион байгуулах		
		14) Компьютер сургалтын интерактив программ хангамжийг хөнгөлөх		
		15) МХХТ-ийн хэрэглэгчдийг хичээлийг телевизээр нэвтрүүлэх		
		16) Зөвлөгөө, тусламж өгөх үйл ажиллагааг дэмжих		
		17) МХХТ-ийн мэдлэгийн үнэлэмжийг боловсронгуй болгох		
	6.2 Төр, засгийн үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх	1) Сонгуулийн системийг МХХТ-ийг ашиглан үе шаттай өөрчлөх (бүртгэл, санал өгөх, санал тоолох, гр дүнг тооцох гм.)	80.0	Гадаадын төсөл
		2) Нэр дэвшигч, сонгогчдын онлайн мэтгэлцээн, хэлэлцүүлгийг бий болгох		
		3) Хуулийн онлайн зөвлөгөө, олон нийтийн форум, хэлэлцүүлэг бий болгох		
		4) МХХТ-ийг ашиглан бодлого боловсруулах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх		
		5) Хууль тогтоомжийн төсөлд онлайн хэлэлцүүлгээр дамжуулан олон нийтийн санал авч тусгадаг болох		
		6) Албан тушаалтанд хандсан хүсэлт, гомдол, саналыг холбогдох байгуллагад шилжүүлэх цахим тогтолцоог бий болгох		
		Дүн	2,120.0	
	МХХТ-ийг ашиглах чадвар, хүний нөөцийн хөгжил			
	7.1. Хүн бүрт МХХТ-ийг эзэмшүүлэх, дадал олгох			
	7.2. Төрийн албан хаагчдын МХХТ-ийн боловсролыг дээшлүүлэх			
	7.3. МХХТ-ийн чиглэлээр мэргэшсэн мэргэжилтэн, судлаачид бэлтгэх		3,600.0	төсөв, гадаадын төсөл, хувийн хэвшил
		Дүн	3,600.0	
Нийт дүн			134,384.0	

LIVEWORKSHEETS